



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэн 7-р сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ХЭА-2022/153/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Чингис хот 2022 он	Тэргүүлэх аудитор:	Ч.Эрдэнэбаатар
	Утас:	70562112
	Аудитын менежер:	Д.Оюунтуяа
	Утас:	99775390
	Өндөрхаан итгэл аудит ХХК-ийн:	
	Аудитор:	Б.Маналсүрэн
	Утас:	99059424

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан .....	5
3.1 Ерөнхий зүйл .....	5
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	5
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	5
3.4 Материаллаг байдал .....	6
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	6
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	6
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	8
3.8 Аудитын гол асуудал .....	8
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	8
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	8
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	8
4. Аудитын илрүүлэлт .....	9
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	9

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2022.03.23 № 329

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Аудитын санал дүгнэлт гаргах тухай Г

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын долоодугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хэнтий аймгийн Хэрлэн сумын долоодугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас 14,400.0 мянган төгрөгийн, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлаас 6,999.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, хоолны зардлыг 503,5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д Үнэн зөв байх, Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны Хоолны зардлын норматив тогтоох тухай 450 тоот тогтоолоор батлагдсан 8-10 цаг ажилладаг цэцэрлэгт нэг хүүхдийн нормыг 2475 төгрөгөөр тогтоосныг баримтлаагүй байгаа нь УСНББОУС-1,2,12,24 холбогдох заалтуудтай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

E:/DOTOOD AJIL/БХ 2022/явсан бичиг/А4 20220323 329

023033438

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2021 оны 12- сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>109,389,671.54</b>	<b>124,844,847.54</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	-
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	109,389,671.54	124,844,847.54
351	<b>Түүхий эд материал</b>	6,328,243.54	6,328,243.54
35110	Тусгай зориулалттай материал	6,328,243.54	6,328,243.54
35130	Эм боох материал	-	-
354	<b>Хангамжийн материал</b>	103,061,428.00	118,516,604.00
35410	Бичиг хэргийн материал	3,945,760.00	4,239,159.00
35420	Аж ахуйн материал	2,177,156.00	1,337,274.00
35440	Түлш, шатах тослох материал	690,000.00	500,000.00
35460	Хүнсний материал	3,954,734.00	2,374,473.00
35470	Бусад хангамжийн материал	92,293,778.00	110,065,698.00
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	-	-
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>465,607,502.85</b>	<b>445,905,574.73</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	465,607,502.85	445,905,574.73
392	<b>Биет хөрөнгө</b>	386,382,502.85	366,680,574.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	363,614,222.96	363,614,222.96
39202	Хуримтлагдсан элэгдэл	(33,873,757.68)	(51,087,836.52)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	58,716,395.00	58,716,395.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(33,055,307.42)	(42,080,004.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,851,533.00	59,251,533.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,888,395.53)	(26,189,173.14)
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,299,000.00	5,299,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(281,187.48)	(843,562.44)
393	<b>Биет бус хөрөнгө</b>	79,225,000.00	79,225,000.00
39301	Програм хангамж	350,000.00	350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(350,000.00)	(350,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	79,225,000.00	79,225,000.00
394	<b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>	-	-
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>574,997,174.39</b>	<b>570,750,422.27</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>574,997,174.39</b>	<b>570,750,422.27</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	574,997,174.39	570,750,422.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	79,225,000.00	79,225,000.00
51101	Өмч: - төрийн	79,225,000.00	79,225,000.00
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(23,521,745.55)	(27,768,497.67)
51210	Өмнөх үеийн үр дүн	(23,521,745.55)	(23,521,745.55)
51220	Тайланг үеийн үр дүн	-	(4,246,752.12)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,549,026.94	8,549,026.94
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>574,997,174.39</b>	<b>570,750,422.27</b>

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

/Торгоогоор/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>433,631,430.00</b>	<b>348,819,500.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>21,982,230.00</b>	<b>-</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>21,982,230.00</b>	<b>-</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,982,230.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	21,982,230.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>411,649,200.00</b>	<b>348,819,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>382,793,600.00</b>	<b>320,287,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		-
131007	Тусгай зориулалтын шилжүүлдгээс санхүүжих	382,793,600.00	320,287,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>555,000.00</b>	<b>1,135,300.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,100,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	555,000.00	35,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>28,300,600.00</b>	<b>27,397,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,300,600.00	27,397,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛЫН ДҮН</b>	<b>379,445,239.59</b>	<b>353,066,252.12</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>379,445,239.59</b>	<b>353,066,252.12</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>356,243,587.92</b>	<b>343,478,873.25</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>218,583,515.00</b>	<b>224,698,218.00</b>
210101	Үндсэн цалин	162,115,691.00	141,063,760.00
210102	Нэмэгдэл	38,310,597.00	65,926,801.00
210104	Урамшуулал	18,157,227.00	17,707,657.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>29,252,980.33</b>	<b>29,991,311.26</b>
210201	Тэтгэврийн даатгал	20,602,776.27	20,384,603.26
210202	Тэтгэмжийн даатгал	2,276,156.56	2,401,678.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,787,325.80	1,931,358.00
210204	Ажилгүйдлийн даатгал	417,250.32	470,319.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,169,471.38	4,803,353.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>20,198,124.00</b>	<b>19,404,632.62</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,903,384.00	2,538,090.62
210302	Түлш, халаалт	15,415,400.00	15,114,242.00
210303	Цэвэр, бохир ус	1,879,340.00	1,752,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,679,683.00</b>	<b>12,280,411.25</b>
210401	Бичиг хэрэг	1,147,500.00	880,100.00
210402	Тээвэр, шатахуун	608,960.00	690,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	975,736.00	812,867.25
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	595,300.00
210406	Бага үнэтэй, гүрэн эзгйдэх, ахуйн эд зүйлс	15,287,487.00	9,302,144.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>20,280,531.00</b>	<b>9,183,173.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,550.00	59,250.00
210502	Хоол, хунс	20,269,981.00	9,123,923.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,817,100.00</b>	<b>-</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210604	Урсгал засвар	5,817,100.00	-
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>100,000.00</b>	<b>48,000.00</b>
210702	Дотоод албан томилот	100,000.00	48,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,824,000.00</b>	<b>10,240,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	9,500,000.00	9,700,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	540,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>33,507,654.59</b>	<b>37,633,127.12</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,255,890.00	3,531,199.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,251,764.59	34,101,928.12
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>23,201,651.67</b>	<b>9,587,378.87</b>

2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	250,000.00	6,300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	6,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	87.00	508,967.38
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	87.00	508,967.38
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,951,564.67	2,778,411.49
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,951,564.67	2,778,411.49
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>54,186,190.41</b>	<b>(4,246,752.12)</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>54,186,190.41</b>	<b>(4,246,752.12)</b>

## АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛГИЙН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	589,969,893.00	8,549,026.94	(77,707,935.96)	520,810,983.98
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>589,969,893.00</b>	<b>8,549,026.94</b>	<b>(77,707,935.96)</b>	520,810,983.98
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	54,186,190.41	54,186,190.41
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>589,969,893.00</b>	<b>8,549,026.94</b>	<b>(23,521,745.55)</b>	574,997,174.39
D01	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>589,969,893.00</b>	<b>8,549,026.94</b>	<b>(23,521,745.55)</b>	574,997,174.39
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>589,969,893.00</b>	<b>8,549,026.94</b>	<b>(23,521,745.55)</b>	574,997,174.39
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(4,246,752.12)	(4,246,752.12)
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>589,969,893.00</b>	<b>8,549,026.94</b>	<b>(27,768,497.67)</b>	570,750,422.27

## АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

/Тогтоогоор/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>411,649,200.00</b>	<b>348,819,500.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>411,649,200.00</b>	<b>348,819,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	382,793,600.00	320,287,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	382,793,600.00	320,287,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	555,000.00	1,135,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,100,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	555,000.00	35,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	28,300,600.00	27,397,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,300,600.00	27,397,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>389,834,200.00</b>	<b>334,419,500.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>389,834,200.00</b>	<b>334,419,500.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>361,572,548.33</b>	<b>324,832,121.13</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	218,583,515.00	224,698,218.00
210101	Үндсэн цалин	162,115,691.00	141,063,760.00
210102	Нэмэгдэл	38,310,597.00	65,926,801.00
210104	Урамшуулал	18,157,227.00	17,707,657.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,252,980.33	29,991,311.26
210201	Тэтгэврийн даатгал	20,602,776.27	20,384,603.26
210202	Тэтгэмжийн даатгал	2,276,156.56	2,401,678.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,787,325.80	1,931,358.00
210204	Ажилгүйдлийн даатгал	417,250.32	470,319.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,169,471.38	4,803,353.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,198,124.00	19,404,632.62
210301	Гэрэл, цахилгаан	2,903,384.00	2,538,090.62
210302	Түлш, халаалт	15,415,400.00	15,114,242.00
210303	Цэвэр, бохир ус	1,879,340.00	1,752,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	28,613,831.00	20,751,747.25
210401	Бичиг хэрэг	2,405,900.00	580,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,298,960.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	975,736.00	812,867.25
210404	Ном, хэвлэл	64,800.00	61,998.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	595,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,208,435.00	18,200,682.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	32,666,350.00	8,174,312.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	355,850.00	59,250.00
210502	Хоол, хүнс	19,598,000.00	7,543,662.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,712,500.00	571,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,985,100.00	7,483,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		-
210604	Урсгал засвар	4,985,100.00	7,483,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	100,000.00	48,000.00
210702	Дотоод албан томилолт	100,000.00	48,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,824,000.00	10,240,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,500,000.00	9,700,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	540,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	17,348,648.00	4,040,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	157,000.00	156,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,191,648.00	3,883,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>28,261,651.67</b>	<b>9,587,378.87</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,310,000.00	6,300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,310,000.00	6,300,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	-

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	87.00	508,967.38
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	87.00	508,967.38
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,951,564.67	2,778,411.49
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,951,564.67	2,778,411.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<b>21,815,000.00</b>	<b>14,400,000.00</b>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<b>21,815,000.00</b>	<b>14,400,000.00</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<b>21,815,000.00</b>	<b>14,400,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	21,815,000.00	14,400,000.00
223001	Бусад хөрөнгө	21,815,000.00	14,400,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<b>(21,815,000.00)</b>	<b>(14,400,000.00)</b>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	347,684,200.00	344,396,821.13
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	347,684,200.00	344,396,821.13
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	341,084,200.00	338,096,821.13
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	224,777,500.00	224,698,218.00
210101	Үндсэн цалин	164,586,900.00	141,063,760.00
210102	Нэмэгдэл	42,421,600.00	65,926,801.00
210104	Урамшуулал	17,769,000.00	17,707,657.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	31,178,400.00	29,991,311.26
210201	Тэтгэврийн даатгал	21,309,200.00	20,384,603.26
210202	Тэтгэмжийн даатгал	2,467,300.00	2,401,678.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,973,900.00	1,951,358.00
210204	Ажилгүйдлийн даатгал	493,400.00	470,319.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,934,600.00	4,803,353.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,912,000.00	19,404,632.62
210301	Гэрэл, цахилгаан	2,540,000.00	2,538,090.62
210302	Түлш, халаалт	14,512,000.00	15,114,242.00
210303	Цэвэр, бохир ус	2,860,000.00	1,752,300.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,312,100.00	19,616,447.25
210401	Бичиг хэрэг	105,900.00	105,900.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,085,800.00	812,867.25
210404	Ном, хэвлэл	64,800.00	61,998.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн усгал, ариут	850,000.00	470,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,705,600.00	17,665,682.00
2105	<b>Нормативт зардал</b>	8,630,500.00	8,174,312.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	59,500.00	59,250.00
210502	Хоол, хүнс	7,999,600.00	7,543,662.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	571,400.00	571,400.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,485,200.00	7,483,600.00
210604	Урсгал засвар	7,485,200.00	7,483,600.00
2107	<b>Томилот, зочны зардал</b>	108,200.00	48,000.00
210702	Дотоод албан томилолт	108,200.00	48,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хура</b>	24,640,000.00	24,640,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	24,100,000.00	24,100,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,040,300.00	4,040,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	156,900.00	156,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,883,400.00	3,883,400.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	6,600,000.00	6,300,000.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6,600,000.00	6,300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,600,000.00	6,300,000.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	-
223001	Бусад хөрөнгө	-	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	347,684,200.00	344,396,821.13
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	320,287,000.00	317,508,588.51
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	320,287,000.00	317,508,588.51
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	27,397,200.00	26,888,232.62
132001	Орон нутгийн төсвөөс	27,397,200.00	26,888,232.62
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	22.00	22.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00

## АУДИТ ХИЙГДСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ПЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>1,135,300.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>1,135,300.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	1,135,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	1,135,300.00
210401	Бичиг хэрэг	-	475,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	125,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	535,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	1,135,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	1,135,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,100,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	35,000.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өндөрхаан итгэл аудит ХХК-ийн аудитор Б.Баярмаа, аудиторын туслах Б.Мөнхзул нар гүйцэтгэж, хяналтыг компанийн захирал, аудитор Б.Маналсүрэн, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өндөрхаан итгэл аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг Сургуулийн өмнөх насны боловсролын тухай хуулиар дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: “Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэж заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлаа сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 379,455.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,794.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3,035.6 мянган төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж 2,824.5 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,246.8 мянган төгрөгөөр буюу 0.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	109,389.7	124,844.8	15,455.1
Үндсэн хөрөнгө	465,607.5	445,905.6	(19,701.9)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>574,997.2</b>	<b>570,750.4</b>	<b>(4,246.8)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	589,969.9	589,969.9	-
Хуримтлагдсан үр дүн	(23,521.7)	(27,768.5)	(4,246.8)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,549.0	8,549.0	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>574,997.2</b>	<b>570,750.4</b>	<b>(4,246.8)</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 124,844.8 мянган төгрөг болж 15,455.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 44,467.8 мянган төгрөгийн бараа материал

худалдан авч 29,012.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 445,905.6 мянган төгрөг болж 19,701.9 мянган төгрөгөөр буурсан нь 14,400.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч тайлант оны 34,101.9 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар хорогджээ.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл алдагдал 27,768.5 мянган төгрөг болж, 4,246.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгийн өсөлт нөлөөлсөн байна..

Хэнтий аймгийн Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 84,811.9 мянган төгрөгөөр буюу 19.5 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь улсын төсвөөс олгосон санхүүжилт 62,506.6 мянган төгрөгөөр буурч, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 21,982.2 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 26,379.0 мянган төгрөгөөр буюу 7.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлуудыг авч үзвэл хангамж бараа материалын зардал 6,399.3 мянган төгрөгөөр, нормативт зардал 11,097.3 мянган төгрөгөөр буурсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 471,647.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 123,962.9 мянган төгрөгөөр бууруулан нийт зарлагыг 347,684.2 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 45,360.5 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 9,975.4 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 62,283.5 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 347,684.2 мянган төгрөгөөр баталсанаас 320,287.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 27,397.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 320,287.0 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 27,397.2 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус авч, урсгал үйл ажиллагаанд 344,396.8 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 2,778.4 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 509.0 мянган төгрөгийг тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 344,396.8 мянган төгрөг буюу 99.0 хувьтай байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 1,135.3 мянган төгрөгийн орлого орж, 1,135.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал илрээгүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

#### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй, өмнөх онд 1 зөвлөмж авсан ба биелэлт 100 хувь хэрэгжсэн.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

#### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 22,013.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 503.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 21,399.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 110.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлээ.

##### **4.1 Залруулсан алдаа**

Залруулсан алдаа байхгүй.

##### **4.2. Төлбөрийн акт**

4.2.1 Тайлант онд 1 хүүхдэд ногдох хоолны зардлыг 503.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь ЗГ-ын 450 дугаар тогтоолын холбогдох заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

##### **4.3. Албан шаардлага**

4.3.1 Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас 14,400.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, БҮТЭЗ-аас 6,999.6 мянган төгрөгийн хивсэнцэр тус тус худалдан авч батлагдсан төсвийг эдийн засгийн ангилал зөрүүлэн зарцуулсан нь Сангийн Сайдын 2021 оны 190 дугаар тушаалын холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

##### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал.**

##### **Илрүүлэлт:**

4.4.1. Шалгагдагч байгууллагын төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн дүн нягтлан бодох бүртгэлд бүртгэгдсэн дүнгээс 110.0 мянган төгрөгөөр дутуу байгаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтууд, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Цаашид цахим төлбөрийн баримтгүй худалдан авалт хийхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Хэрлэн сумын 7-р цэцэрлэг	3	22,013.1			1	503.5	1	21,399.6	1	110.0
Дүн		3	22,013.1			1	503.5	1	21,399.6	1	110.0



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 33/23910610  
ХЭА 2022/153/НА СТА ТУС

Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын долоодугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тайлант онд нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг нормативаас 503.5 мянган төгрөгөөр хэтрүүлсэн зарцуулсан.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Хоолны зардлын норматив тогтоох тухай" 450 тоот тогтоолоор батлагдсан "Цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 2,475 (хоёр мянга дөрвөн зуун далан таван) төгрөгөөр тогтоосныг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн", 4.2.3.6 "Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нормативаас хэтрүүлж зарцуулсан 503.5 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хэрлэн сумын долоодугаар цэцэрлэгийн эрхлэгч Г.Саранцэцэг, нягтлан бодогч Ж.Хулан нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ӨНДӨРХААН ИТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Б.МАНАЛСҮРЭН

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА



023057789



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 23

Дугаар 217/23910610  
ХТЭА-2022/153/НА ЕТА ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын долоодугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас 14,400.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, БҮТЭЗ-аас 6,999.6 мянган төгрөгийн хивсэнцэр тус тус худалдан авч, батлагдсан төсвийг эдийн засгийн ангилал зөрүүлэн зарцуулсан.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8 “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулдаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн сумын долоодугаар цэцэрлэгийн эрхлэгч Г.Сансарцэцэг, нягтлан бодогч Ж.Хулан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨНДӨРХААН ИТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН МЕНЕЖЕР

Б.МАНАЛСҮРЭН

Д.ОЮУНТУЯА

